



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/494

Булган

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах,
гэрчилгээг шинэчлэх тухай

Монгол Улсын “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, “Эрүүл мэндийн тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.13 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 298 дугаар тушаал, аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох болон хугацааг сунгах, гэрчилгээг шинэчилж байгаа байгууллагуудын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан болон шинээр авч байгаа байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, холбогдох хууль тогтоомж, тушаал, зааварт тусгагдсаны дагуу хяналт тавьж, зөрчил дутагдал үүсэхээс сэргийлэх, үүссэн даруйд холбогдох арга хэмжээг авч ажиллахыг комисс /С.Нарантуяа/-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд холбогдох хууль, тогтоомж, тушаал, зааврыг баримтлан хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс /Э.Түвшинмөнх/, Мэргэжлийн хяналтын газар /С.Баясгалан/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА *Д.Баяр* З.БАТЗОРИГ



Аймгийн Засаг даргын 2017 оны ...
09 сарын 17-ны өдрийн 2 дугаар
захирамжийн хавсралт

МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ
ШИНЭЭР АВЧ БАЙГАА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Гэрчилгээний дугаар	Тусгай зөвшөөрөл хугацаа
1.	Баян-Агт сумын "Ар хунх" ХХК-ний эмийн сан	ЭСХ-17/04/338	3 жилээр
2.	"Мөнгөний тархи" хоршооны "Smile" шүдний үүдэн эмнэлэг	ЭХ-17/04/351	3 жилээр

МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАСАН
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Сунгагдсан хугацаа	Тусгай зөвшөөрөл дуусах хугацаа
1	Хишиг-Өндөр сумын "Хишиг-Өндөр тур" сувилал	5 жилээр	2022.09.25

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭГ ШИНЭЧЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГУУД

№	Байгууллагын нэр
1	Аймгийн Нэгдсэн эмнэлэг
2	Баян-Агт сумын Эрүүл мэндийн төв
3	Баяннуур сумын Эрүүл мэндийн төв
4	Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төв
5	Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төв
6	Дашинчилэн сумын Эрүүл мэндийн төв
7	Могод сумын Эрүүл мэндийн төв
8	Рашаант сумын Эрүүл мэндийн төв
9	Сайхан сумын Эрүүл мэндийн төв
10	Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төв
11	Хангал сумын Эрүүл мэндийн төв
12	Хялганат тосгоны Эрүүл мэндийн төв
13	Орхон сумын Эрүүл мэндийн төв
14	"Цоожид" өрхийн Эрүүл мэндийн төв
15	"Эмийн цэцэглэн" өрхийн Эрүүл мэндийн төв
16	Могод сумын "Хульж" сувилал
17	"Ман-Од" хувийн хэвшлийн эмнэлэг
18	"Цанлэг" хувийн хэвшлийн эмнэлэг
19	"Сожд" хувийн хэвшлийн эмнэлэг
20	"Энх-Үрс" хувийн хэвшлийн эмнэлэг